

МОНГОЛ ХЭЛНИЙ УНШИХ БИЧИГ

蒙古语阅读教程

第一册

编者 张吉焕

中国人民解放军外国语学院

中亚南亚军事语言系

二〇〇四年十二月

前 言

《蒙古语阅读教程》(二年级用)为蒙古语(复语制)专业二年级阅读课教材,共分上、下两册。

上、下两册均为18课,上册供第五学期使用,下册供第六学期使用。教材内容新,范围广,有关于蒙古社会文化、风土人情、历史地理、科普知识的文章,也有关于世界历史地理和风俗文化的文章,题材广泛,内容丰富,语言规范,难度适中。课文由浅入深,循序渐进,融趣味性和可读性于一体,有利于学员扩大知识面,提高阅读理解能力。

每篇课文的生词、常用词语均标注在词语后面,一目了然,便于学员阅读理解;每篇课文后面均配有练习,类型包括回答问题、总结概述和翻译段落,目的是检查学员的阅读理解能力,提高其综合概括能力。

由于编者水平有限,错误与不妥之处在所难免,敬请批评指正。

编 者

2004. 12

ГАРЧИГ

1-р ХИЧЭЭЛ	1
Диваажинд хүргэх оньст тэрэг	
2-р ХИЧЭЭЛ	3
Малч жаал	
3-р ХИЧЭЭЛ	7
Хүслийн тухай үлгэр	
4-р ХИЧЭЭЛ	10
Чулуутай танилцсан нь	
5-р ХИЧЭЭЛ	14
Монгол ардын хувьсгал(—)	
6-р ХИЧЭЭЛ	18
Монгол ардын хувьсгал(二)	
7-р ХИЧЭЭЛ	22
—、Эх орон	
二、Төрийн сүлд	
三、Төрийн далбаа	
8-р ХИЧЭЭЛ	26
—、Энэ сарын 15-наас дулаан өгч эхэлнэ	
二、Өрх бүр компьютертэй болох төсөл хэрэгжихээр боллоо	
三、Энэ жил эрт хүйтэрч, цас их орж болзошгүй	
9-р ХИЧЭЭЛ	30
—、9-р сарын 1-Ер бусын өдөр	
二、Хичээлийн бэлтгэлээ гэж...	
三、Анхны хичээл "Миний гэр бүл"	
10-р ХИЧЭЭЛ	34
"Миний ээж" уралдааны дүн гарч, эхний 100 байранд орсон хүүхдүүдийн бүтээлийг багтаасан ном хэвлэгдлээ(—)	
11-р ХИЧЭЭЛ	38
"Миний ээж" уралдааны дүн гарч, эхний 100 байранд орсон хүүхдүүдийн бүтээлийг багтаасан ном хэвлэгдлээ(二)	

12-р ХИЧЭЭЛ.....	43
Монголтой бид яаж харьцаагаа хөгжүүлэх ёстой вэ?(一)	
13-р ХИЧЭЭЛ.....	49
Монголтой бид яаж харьцаагаа хөгжүүлэх ёстой вэ?(二)	
14-р ХИЧЭЭЛ.....	58
Ихэр охидын ээж шүтдэг шашнаасаа болж амь насаараа дэнчин тавьжээ	
15-р ХИЧЭЭЛ.....	66
Архангай аймгийн товч танилцуулга	
16-р ХИЧЭЭЛ.....	75
一、Сүхбаатар аймаг	
二、Хэнтий аймаг	
17-р ХИЧЭЭЛ.....	81
Үлгэрүүд	
一、Алтан гургалдай	
二、Шатар тоглосон нь	
三、Хааныг давсан нь	
四、Долоон настай хүү	
18-р ХИЧЭЭЛ.....	89
Би дахиж миссийн тэмцээнд оролцохгүй	

1-р ХИЧЭЭЛ

Диваажинд хүргэх оньст тэрэг

Жамбал дархан 工匠 одоо 83 нас хүрчээ. Жамбал гуай алдартай дархан билээ. Мод, төмөр, алт, мөнгө цөмөөр нь л юуг ч хийж байжээ. Өтөлснөөс 变老, 上年纪 гар хуруу нь эвлэхээ 协调, 灵活 больж, нүдний нь хараа муудахаар авгайчуул хувин, шанага 勺子 засах зэрэг аар саархан 微小的 юм хийлгэх болов.

Жамбал гуай тэр жилийн зун, гэнэт ямар нэг сонин юм дархалж 手工做 эхлэв. Бид юу хийхийг нь үзэх гэж өдөржин сахидаг боллоо. Өвгөн дархан эхлээд хоёр том, нэг жижиг дугуй хийж дараа нь хоёр том дугуйгаа араануудаар 齿轮 холбов.

Одоо багачуул байтугай томчуул ч гайхаж сонирхох боллоо. Харин Жамбал гуай чухам юу дархалж байгаа тухайгаа хэнд ч хэлэхгүй, хүн шалгаагаад 求问 байвал уурладаг болов. Нөгөө гурван дугуйдаа баахан 好多 араа шүд тааруулан нимгэн хавтгай төмрөөр 铁片 хоёр том далавч хийж бэхлэв.

Тийнхүү нэг өглөө үзэгдээгүй сонин юм болох дөхлөө. Хүүхдүүд бид, тэр гайхамшигт төмөр шувуу хэрхэн нисэхийг үзэх гэж хэд хоног тэсэж ядан 忍不住 хүлээсэн билээ. Тэр өглөө тэнгэр тогтуун 无风的 салхи ч үгүй, үүл ч үгүй нисдэг л юм бүхэн нисэхээр байлаа.

Жамбал гуай төмөр далавчтай тэргээ зам дээр аваачиж урт олсоор 麻绳 оосорлон биднээр чирүүлж гүйлгэв. Бид төмөр далавчтай тэрэг хэзээ л хөх тэнгэр өөд хөөрөн нисэх бол гэж эргэн эргэн харсаар чадлынхаа хэрээр гүйцгээлээ. Жамбал гуай өөрөө ч бидний хойноос гүйж явав. Тэгтэл тэр тэрэг маань нисэх байтугай сөөм (拇指与食、中指之间的距离) ч хөөрсөнгүй. Тэгээд бид гайхамшигт тэргээ урамгүйхэн чирсээр дархны саравчны хажууд авчирч тавив.

Ямар нэг эрэг шураг 螺旋, 螺纹 дутсанаас л ийм юм боллоо. Тэрнээс биш хөөрөх л байсан даа гэж бид бодоод өнгөрсөн юм.

Далавчит тэргээ амжилтгүй туршсандаа өвгөн дархан их гутарч 情绪不好, 难过 тэр өдөр аяга тагш юм уучхаад:

-Би юу ч хийж чадна, харж байгаарай! Би энэ далавчит тэргээрээ диваажинд нисэж очно гэж төмөр далавчаа унжуулсан 使...垂下 тэргээ тойрон хашгирч явав. Маргааш нь, хөөрхий Жамбал гуай орноосоо босож чадахгүй болсон бөгөөд гурав хоногийн дараа талийгаач болж 去世 билээ.

Өвгөн дархан үхэн үхтлээ сансарт нисэх тэрэг хийж чадна гэж итгэж явсан бизээ. Харин урд гарсан чихнээс, хойно гарсан эвэр урт 青出于蓝而胜于蓝 гэгчээр залуу үе маань л ийм тэрэг бүтээж байна.

Дасгал:

1. Жамбал гуай юу хийдэг хүн байсан бэ?
2. Гэтэл Жамбал дархан яагаад хувин, шанага засах зэрэг аар саархан юм хийх болсон бэ?
3. Тэр жилийн зун Жамбал гуай ямар тэрэг хийж эхэлсэн бэ?
4. Хүүхдүүд юу үзэх гэж хүлээв?
5. Тэр далавчит тэргийг нисгэхийн тулд яасан бэ?
6. Өвгөн дархан юунд гутрав?
7. Залуу үе маань юу бүтээж байна вэ?
8. 5-р бадгийг хятадаар орчуул.

2-р ХИЧЭЭЛ

Малч жаал

Хавар болж мал төллүүлэхээр 使...产羔 Дундговь аймгийн нэгэн суманд очлоо.

Миний очсон айл 1-8 настай зургаан хүүхэдтэй. Тэднийх гэртээ яг л хотын айл шиг тохилог сууна. Нэгдлийн 合作社 дарга надад:

-Чи ашгүй тун хашир 经验丰富的 малчныд оногдлоо 被分配 доо. Тэдний наман настай хүү Хүрэл нь тун яггүй 很好的, малч хүүхэд. Тэр ч чамд бараг багш гэсэн үг. Мал маллахад тулгамдах 紧张, 慌张 юм их гарна шүү гэж хэлэв. Би дотроо: "За гайгүй байлгүй, би мал дагаж л өссөндөг 长大的. Хэдий би сургууль эрдмийн мөр хөөсөн ч гэсэн малчны хүүхэд шүү дээ" гэх мэтийг бодож явав. Шувуу өдөө, хүн нэрээ гэсэн юм. Нэрээ гутаахгүй 败坏 олигтойхон шиг ажиллана даа гэж бодсоор хүрч ирлээ.

Тэгээд найман настай хүү Хүрэлтэй нь өдөр бүр хонинд явдаг байв. Бид хоёр нэгэн атны 骆驼 бөхөөс 驼峰 хурганы уут 羊羔产包 3-4-ийг зүүчихээд түрүүчийнхийг нь гэртээ хүргээд өдөр туж 整天 гэр бэлчээр хоёрын хооронд хурга зөөнө.

Нэгэн өдөр хонио бэлчээгээд явж байтал Хүрэл:

-Ах аа! Энэ хүрэн хүзүүтэй хонийг хараач! Одоо цай чанах хэртэй (хиртэй) 大约, 接近 болоод хургалах нь байна гэв.

-Үгүй ээ, ер, яаж байна? Миний дүү?

-Та тэр явж байгаа байдал, сүүлийг нь хараач? гэв.

Би анхандаа хичнээн харавч олигтой содон шинж олж мэдэхгүй байв? Гэтэл цай чанах хэртэй болсны дараа нээрээ л өнөө хүрэн хүзүүтэй хонь хургалав. Ингэснээр 4-5 өдрийн дараагаар би ажиглан ажигласаар арайхийж

хонины хургалах дөхөж байгаа шинж тэмдгийг хэвтэж босохоос нь өмнө мэддэг болчихов.

Тэгтэл бас малын зүс 毛色 нарийн ялгахгүй өдий хүрсэн минь илрэв. Хув 小耳朵 хонь гэхэд л хув цэнхэр, хув түнжин 秃头的, Хув хялман 毛色全白而眼睛青蓝的 гэх мэт нарийн ялгаатай. Тэр бүрд Хүрэл маань наддаа багш болов. Нэгэн өдөр ууттай хургануудаа Хүрэл хүүтээр гэр өөдөө өгч явуулчихаад өөрөө хониныхоо дэргэд хоцров.

Тэгтэл Хүрэл маань намайг даллан 招手, 挥手 хүрэн атныхаа бурантгийг 缰绳 байн байн дугтчин 拽着 ташуурдаж нэлээд яаруу 匆忙地, 急忙地 айсуу 走过来. Над уруу дөхмөгц

-Ах аа, цас орох нь байна. Эцэстээ шуурч ч магадгүй, ямар ч болсон хоёулаа хонио нөмөр 避风处 бараадуулъя 使跟随, 引到 гэв.

Тэнгэр ерөнхийдөө бүрхэг бүүдгэрдүү 非常阴沉 байсан боловч цас орох нь гэмээр шинж төлөв огт алга. Би нэлээд бассан 轻视 маягтай инээмсэглэж,

-Гайгүй байлгүй ээ! гээд тэнгэр өөд шинжих мэт эргэн тойрон ажиглаад:

-Шөнө л юу бол гэхээс одоохондоо тэвдэх 慌张, 慌乱 юм алга байна гэж тайван хэлэв. Хүрэл:

-Үгүй ээ, ах аа! Болохгүй гэж тэвдэн хонио бөөгнүүлж 聚集 нөмөр тийш тууж эхэллээ.

-За даа. Будаач будаач гэхээр сахлаа будав гэдэг болох нь дээ гэж дотроо дургүйцэв. Дэмий л Хүрэлийг дагаж хонио нөмөр тийш туулцав. Бид хоёр нөмөр газар очоод хонио тогтоон хонь ч сайхан тархан идээшилж эхэлтэл цас малгайлан орж 下鹅毛大雪 эхлэв.

Үлгэрийн баатар, эрийн гурван наадамд түрүүлчихээд "Нэг наадам минийх болов уу" гэж ханхалздаг 洋洋得意, 骄傲 шиг Хүрэл энэ дээр нэг наадам миний болов уу? Та шөнө л юу бол? гэхээс өнөөдөр орохгүй гэсэн биш билүү? гэж ам асуух болов уу гэж бодов. Гэтэл юу ч дурсахгүй 提起, 提到

өнгөрөв.

-Хүрэл чи цас орох нь гэж яаж мэдэв ээ? гэхэд:

-Мэдэлгүй яах вэ? Агаар бүгчим 闷, 闷热, бас шинэ цасны үнэр байн байн хамарт сэнгэнээд 袭鼻 байсан шүү дээ гэв.

-Шинэ орох цас ямар үнэртэй байдаг юм бэ? гэхэд Хүрэл:

-Ах аа, би тийм гэж ярьж чадахгүй байна. Харин тэгэхдээ бороо цасны үнэрийг орохоос нь хагас цагийн өмнө сайн мэднэ гэв. Тэр жаал өдөр туж хээр өнжихдөө 渡过, 生活, үнэг хярсны 沙狐 мөрийн ялгаа, хонь ямаа хоёрын мөрний ялгаа гэх мэт өдий төдий шинэ юм надад заав.

Хүрэл маань нас биенээсээ хэтэрсэн 超过 ухаалаг хүүхэд байв. Надад хорь гаруй цэцэг өвсний нэр зааж, тэр ч байтугай ямар нь таргалуулдаг, ямар өвс, цэцэг малд хортойг хүртэл таниулав.

Нэг өдөр харьж яваад "Нар их сайхан жаргалаа. Маргааш лав сайхан өдөр болно" гэж батлах аялгаар хэлэв. Нээрээ л маргааш нь өглөө эрт босож, тэнгэрийн байдал ажиглалат Хүрэл хүүгийн тааврыг батлах шиг тэнгэр тун сайхан болов. Хүрэл, захалсан 溜边走 хонь буцааж ирээд миний дэргэд суув.

-Ах аа! Үүнийг хараач гэж адууны нойтон хомоол 马粪 харуулав. Би гайхаж:

-Юу вэ? гэж огцом 性急地 асуув. Хүрэл:

-Харахгүй юу? Морины хомоол байна гэв.

-За хаанаас даа наадах чинь, гүүнийх ч юм уу, мориных ч юм уу гэхэд Хүрэл инээмсэглэн,

-Ах аа! Энэ чинь мадаггүй мориных, Аав над зааж өгсөн юм. Харахгүй юу? Энэ хажууг нь хар гэв.

Ямар ялгаа байна гээд би, авч эргүүлж тойруулж үзэв.

Гэвч онцгой юм ажиглагдсангүй. Хүрэл маань хэлснээ нотлох санаатай гүйгээд явчив. Гүйж гүйж "За одоо үз, гүүний хомоол энэ" гэв. Хоёуланг нь жишиж 对比, 比较 үзвэл

үнэхээр ялгаатай байлаа.

Ингэж би, морь гүү хоёрын хомоолыг ялгадаг болсон юм. Нэг удаа чөдөртэй 马绊 морио алдчихаад нэг мөр хөөгөөд л явлаа. Нэлээд явтал нойтон хомоол тааралдав. Аваад үзсэн чинь гүүний хомоол байв. Тэгэхээр нь тэр мөрөө орхичихоод зүүн тийшээ явсан чинь миний морь байж байсан юм. Малчин хүнд юм мэдэх багаддагүй гэж өвөө аав хэлдэг байсныг дурсан санав.

Ийнхүү Хүрэл бид хоёр тун түнш болов. Бид хоёр, шөнийн жижүүрт бас цуг гардаг байв. Нэг шөнө бид хоёр гурван хонь хургалсныг эх барьж гэртээ оруулав. Тэгэж явахдаа Хүрэл маань өнөөдөр хонь сайн цаджээ. Маргааш хоёулаа өчигдрийнхөө бэлчээрт очно шүү гэв.

-Хонь цадсаныг чи яаж мэдэв?

-Харахгүй юу? хонины хивж 反刍, 倒嚼 байгаа нь андашгүй гэж өчिव (有礼貌地) 回答.

Анх нэгдлийн даргын надад хэлдгээр мал маллах, өвс бэлчээр шилэх 挑选, 选择, цаг агаарын байдал ажиглах, мал таних эрдэм ухаанаар Хүрэл хүү үнэхээр надад багш байв.

Дасгал:

1. Мал төллүүлэхээр хэн, хаана очив?
2. Нэгдлийн дарга юу гэж хэлэв?
3. Миний очсон айл нь хэдэн хүүхэдтэй вэ? Хүрэл нь хэдэн настай вэ?
4. Хүрэл хүүгийн малч болох нь юугаар илрэв?
5. Хонь хураглах гэдгийг Хүрэл хүү яаж мэдэх вэ?
6. Хүрэл хүүг яагаад багш гэх болов?
7. 4-5-р бадгийг хятадаар орчуул.

3-р ХИЧЭЭЛ

Хүслийн тухай үлгэр

Хөдөө газар нэг эхнэр, хонь хариулж явтал жаахан хүү нь эхдээ гүйж ирээд:

-Ээж ээ, ээж ээ, үлгэр яриж аль! гэсэнд ээж нь хүүгийнхээ толгойг илээд 抚摸 үлгэр хэлж өгөв.

-Эрт урьд цагт хүслийг хангагч чандмань эрдэнэ гэж байдаг байжээ. Тэр эрдэнэ хүний хүссэн юм бүрийг бүтээдэг байжээ. Хүн ямар нэг юмыг хүсвэл тэр хүслээ чандмань эрдэнэд хэлэнгүүтээ тэр эрдэнэд гараа хүргэх хэрэгтэй. Тэгвэл сая түүний хүсэл бүтдэг байлаа. Жишээлбэл, Усгүй хөдөө газар, халуун зун ам цангаавал "Ус хайрла!" гэж хэлээд чандмань эрдэнийг барихад ус их элбэгээр урсан гардаг байлаа.

Тэр чандмань эрдэнэд нэг онцгой чанар байсан. Нэг хүн хүслээ илэрхийлэн хэлж байх үед нөгөө хүн тэр эрдэнэд гараа хүргэвэл түрүүчийн хүний хүсэл, чандманийг гартаа барьсан хүнд боловсорч бүтдэг байжээ. Жишээлбэл, нэг хүн эрдэмтэй болохыг хүсэж тэр хүслээ хэлэх үед өөр хүн тэр чандмань эрдэнэд гараа хүргэвэл гараа эрдэнэд хүргэсэн хүн эрдэмтэй болдог байжээ. Энэ эрдэнийн ачаар түмэн олны санасан хэрэг сэтгэлчлэн 如愿 бүтэж, амар жаргалтай суудаг болжээ.

Гэтэл нэг муу мангас 妖怪, 魔鬼 тэр эрдэнийг хүнээс булаагаад аваачиж гэнэ. Хүн гэдэг амьтан, юм хүсэж эрмэлзэхгүй байж чадахгүй юм. Зовсон зүдэрсэн 精疲力尽 ард олон, хүссэн юм бүрийг чандмань эрдэнэ бүтээгээд л байлаа. Тэр чандмань эрдэнийн бүтээсэн юм бүрийг мангас аваад л байжээ. Учир нь мангас чандмань эрдэнийг гараас гаргахгүй үргэлж атгаад байжээ.

Тэгээд мангас их эрдэмтэй, юмтай болжээ.

Мангас далавчтай болоод нисэж гэнэ. Мангаст ганцхан сайн сэтгэл дутуу байжээ. Мангас сайн сэтгэлгүй учраас чандмань эрдэнийн чадлыг хүнийг хорлоход хэрэглэдэг болжээ. Тэгээд хүн бүр зовоод, ганц мангас жаргаад байжээ.

Мангас тэр эрдэнийг булааж авах гэж олон баатар очиж тулалдсан боловч нэг ч баатар гайтай 有害的 мангасыг дийлж чадалгүй байсаар олон жил өнгөрчээ.

Гэтэл нэг их баатар эр төрж гэнэ. Тэр баатар түмэн хүнтэй нөхөрлөдөг учир тийм их хүчтэй байдаг байжээ. Тэр баатар эр, мангасын байгаа газар, очоод түүнтэй ноцолдож 搏斗 эрдэнийн хэлтэрхийг 碎片, 一部分 булааж аваад иржээ.

Тэр эрдэнийн хэлтэрхий нь бас хүний хүслийг хангах чадалтай байжээ. Тэгээд тэр хүчит баатар сайн сэтгэлтэй тул хэн хүссэн хүнд чандмань эрдэнийн ач тусыг хүртээжээ. Тэр болж сайхан жаргаж гэнэ.

-Тэр баатар одоо хаана байна? гэж хүү нь асуухад ээжий нь:

-Чиний энгэр дээр байна гэж хүүгийн энгэр дээр байгаа Лениний зурагтай тэмдгийг 像章 заав.

-Яасан хачин юм бэ? Тэгвэл тэр чандмань эрдэнийн хэлтэрхий хаа байна? гэхэд эх нь:

-Аа, тэр чандмань бол Орос улсад бий. Ленин чинь орос хүн шүү дээ, хүү минь! гэжээ.

-Ээж ээ чандмань эрдэнэ гэж ямар шүү юм байна? Эрдэнийн чулуу юм уу? гэж хүү асуусанд эх нь:

-Аа хүүхээ, хүслийг хангагч чандмань эрдэнэ гэж юмыг бүтээх хүний хөдөлмөрийг хэлж байгаа юм гэв.

-Тэгвэл мангас гэж хэнийг хэлж байна? Тэр хаа байна? гэхэд эх нь:

-Мангас энд тэндгүй байна. Чи түүнийг том болсон хойно мэднэ. Чи, хүү минь, тэр мангасыг дийлсэн түмэн хүний хүчит баатар шиг эр болоорой! гэсэнд

-Ээж ээ, би яавал тийм баатар эр болох вэ?

-Хэн үнэн санаанаас зориглолд, хэн түмэн ардын төлөө амь биеэ хайрлахгүй зүтгэвэл тэр түмэн сайн нөхөдтэй, түмэн хүний хүчтэй болж их баатар эр болдог юм. Энэ үгийг дуулаад хүү нь:

-Тэгвэл би түмэн буман хүний хүчийг биедээ шингээсэн 吸收 их баатар болоод тэр мангастай очиж байлдана. Тэгээд хүслийг хангагч чандмань эрдэнийг бүхлээр нь олж ирээд, хүн бүгдийн хүслийг хангана гэж өндөр дуугаар хэлэв.

-Чи урьдаар Ленин яагаад тийм хүчтэй болсныг олж мэдэх хэрэгтэй. Үүнийг мэдэхийн тулд Лениний хэлсэн үг, бичсэн номыг урьдаар сайн сурах хэрэгтэй. Тэгвэл чи тэр чандмань эрдэнийг олж чадах хүчтэй болно гэжээ.

Дасгал:

1. Хөдөө газар, нэг эхнэр юу хийж явсан бэ?
2. Хүү нь эхдээ гүйж ирээд юу гэж хэлсэн бэ?
3. Чандмань эрдэнэ хүний хүслийг яаж хангадаг байсан бэ?
4. Чандмань эрдэнэ ямар онцгой чанартай байсан бэ?
5. Чандмань эрдэнийн энэ онцгой цанарыг мангас яаж ашиглав?
6. Мангаст ганцхан юу дутуу байсан бэ?
7. Тэр их баатар эр яагаад их хүчтэй болсон бэ?
8. Тэр баатар мангастай ноцолдож юу олж ирэв?
9. Тэр эрдэнийн хэлтэрхийн ачаар ард олны амьдрал ямар болов?
10. Чандмань эрдэнэ гэж юу вэ?
11. Яавал чандмань эрдэнийг олж чадах хүчтэй болох вэ?
12. 2-4-р бадгийг хятадаар орчуул.

4-р ХИЧЭЭЛ

Чулуутай танилцсан нь

-Ээж ээ, надад тоглоом өгөөч! гэж би нэг өдөр гуйлаа.

Ээж:

-Гол дээр оч! Тэнд чиний тоглоом бэлэн бий гэв. Би гол уруу явлаа. Зуны дунд сарын үед бараг усгүй болон хатдаг мөртлөө хаврын дунд сард **хавь ойрыг** 附近, 周围 усаар ундалж 灌, 淹, эргээ халин 溢出, 溢满 шуугин шаагьдаг зантай уулын догшин 急流 голын хөвөөнд манайх өөдөө уруугаа нүүдэллэн нутагладаг 迁居 байлаа.

Намайг гол дээр очиход айлын хүүхдүүд ямар нэгэн юм эрэх мэт, чулуун дунд доош бөхийн 弯腰 явцгааж байлаа.

-Та нар юу хайж байгаа юм бэ? гэж би сониучлан 好奇地 асуув.

-Тоглоом гэж тэд ам амандаа товчхон хариуллаа.

-Ямар тоглоом? гэж асуувал:

-Ийм тоглоом гэж нэг жаал жижиг дөрвөлжин чулуу үзүүлэв. Тэр чулуу ногоон алаг 花纹 атлаа наранд гялтганан гялалзах дөрвөлжин толботой 斑点 байв. Тэр мэт сонин хачин чулуу байдаг гэдэгт би үнэмшиж ядан барьж үзлээ.

-Энэ бол авдар 箱子. Одоо манайх хамгийн гоё авдартай айл болно гэж тэр чулууг олсон хүү гайхуулав.

-Голын чулуун дотор байхгүй юм үгүй. Авдар сав, аяга, дээл, боов, чихэр, морь, тэмээ цөм бий гэж нэг охин ярилаа. Би хүүхдүүдийг дуурайлж чулуун дотор хайгуул хийж эхэллээ. Анхандаа надад юу ч олдсонгүй. Үүнээс гадна чулуун дотор бүдчиж 跌倒 яваад хөлөө шалбайж 湿透 уйлав. Хүүхдүүд намайг тойрон ирж:

-Битгий уйл. Чулуун дотор эвтэйхэн гишгэж 迈步, 走动 сур. Чулуу их ууртай шүү! гэж нэг охин сануулав.

-Би өвдсөндөө уйлаагүй. Надад тоглоом олдохгүй байна гэж би өчлөө. Тэгтэл миний сайн танил цоохор 有痘痕的, 长麻子的 хамартай жаал:

-Наад хөлийн чинь хажууд нэг морь байж байна. Сайхан цагаан морь! гэв. Ажиглавал, яг морьтай адилхан хэлбэртэй цагаан чулуу байв.

-Нээрээ, яасан хөөрхөн морь вэ? гэж хүүхдүүд шохоорхлоо 沉醉, 陶醉.

-Чи энэ морио миний тэмээгээр сольчих гэж өөр нэг хүүхэд хоёр бөх шиг сэрэвгэр 突起的 юмтай хөх чулуу үзүүлэв.

-Чиний тэмээ ноос нь зулмарчихсан 脱落, 脱毛 юм байна гэж өөр нэг жаал хэлэв.

-Яагаад? гэж нөгөөх нь гайхлаа.

-Яах вэ дээ?! Хөх өнгөтэй байна. Тэмээний ноос зулмарчихлаарлаа ийм чилдэн 全色的, 深色的 хөх арьс гардаг шүү дээ гэж тэд маргав. Энэ бүхэн надад үнэмшигдлээ 令人相信. Би голын чулуун дотроос анх удаа бяцхан хар толботой цагаан морь олов. Үүндээ урамшин үдийн хонь хотолтол 牲畜入圈 гол дотор тэнэв 游玩. Хормой дүүрэн чулуун эдлэлтэй буцаад ирж явахад хүмүүс дайралдаад толгой сэгсрэн 摇头:

-Дээлийн хормой яаж тэснэ 承受住?!

-Мөн их олзтой эр ээ! гэх мэт ярьцгаав. Ээж намайг хараад инээмсэглэж:

-За тэр шүү. Гол дээр тоглоом их байгаа биз? гэв. Би "зөндөө байна. Ээж ээ, би хонь саасны дараа гол уруу явъя" гэж гуйхад:

-Яв яв хэмээн зөвшөөрлөө.

Миний хормойлж ирсэн чулуун дотор юм бүгд байлаа. Хоёр дөрвөлжин чулууг авдар болгов. Хэдэн дугараг чулууг таваг, тогоо, аяга болгож өнгө өнгийн гулуузан 长圆形的 чулуунууд дээл боллоо.

Үдээс хойш нөгөөх цоохор хамарт найз минь ирж:

-Найз аа, хоёулаа манайд очъё гэхэд нь:

-Танай ааваас айж байна гэв. Учир нь цоохор хамартын аав нь бавайсан 胡须丛生 сахалтай аймаар хүн байдаг юм.

-Би өөрөө аав байхгүй юу гэж тэр хүү хэлээд, надаас "чи айж байна уу" хэмээн гараас минь хөтлөн явлаа. Гэр уруугаа биш өөр зүгт явсанд би гайхав. Голын хөвөөний сайхан ногоон зүлгэн дээр ирлээ. Ногоон зүлгэн дээр торгоныхээ шиг дугуй алаг юмс үзэгдлээ. Тэдгээрийн хамгийн захынх дээр ирвэл өнгө өнгийн чулуу дугуйруулан 使成圆圈 өржээ 摆放.

-За, энэ манайх гэж найз маань хуруугаар зангаснаа 指点 "Харахгүй юу, тэр манай шар халтар нохой 黑色带黄斑的狗 хэвтэж байна. Манай нохой их зуумхай 咬人的, 常咬人的 шүү!" гэснээ гарынхаа салаанд буй морь шиг чулууг газар шигтгэж 插入:

-Нохой хорио! гэж. Тэгээд өөрөө:

-Нохой зуухгүй ээ. Уяатай гэж хариулаад над уруу хандаж:

-За, хоёул мориноосоо бууж манайд оръё гэв. Чулуугаар гэр барьж тоглодог ажээ.

-Манай хүүхдүүд тэр тоглож байна гэж найз маань чулуун гэрийнхээ гадаа хаяанд байгаа арван хэдэн жижигхэн бөөрөнхий 圆圆的 чулууг заав. Тэгснээ хөмсгөө зангидаж 皱眉头:

-Болд, чи яагаад чулуу хормойлоод 用衣襟兜 байна? Таван салаа боов идэх нь үү 找抽呀? гэж сүртэй дуугарснаа олон бөөрөнхий чулууны хамгийн багыг зааж:

-Хараач, тэр муу Болд айж байна гэв. Болд гэж нэрлэсэн чулуу нь огт хөдлөхгүй байлаа. Тэгтэл хөрш айлын охин гүйн ирж:

-Батаа, чи яагаад хүүгээ загнаад 生气, 发脾气 байгаа юм бэ? Эвий 哎呀 (表示怜悯, 同情) муу Болд, битгий уйл, за юу! гэж

нөгөөх "Болд" гэж нэрлэсэн чулууг аргадав 安慰. "Болд" чулуу хөдөлгөөнгүй хэвээр.

-Энэ, манай авгай. Дэжид гэж Батаа нөгөө охиныг зааснаа:

-Дэжээ, чи цайгаа хийгээч. Зочин ирчихээд байхад яасан шившигтэй 丢人 юм бэ! гэв. Дэжид шалавхан 较快地, 麻利 хөдөлж гэрийн төв дунд газарт хатгасан 插入 шовгор 圆锥形的 чулуунууд дээр тогоо мэт дүгрэг 圆形的 чулуу тавив. Дараа нь нунтаг 粉状的 цагаан чулуу авч уур 研钵, 臼 шиг юманд хийгээд нүдэж 杵, 捣碎 эхлэв.

Бат болохоор авдар гэгдсэн дөрвөлжин чулуун дээрээс нарийнхан цагаан чулуу авч амандаа зуугаад сорж 吸, 抽:

-Тамхи дуусчихаад туулайн баас татаж байна хө гэж ярив. Энэ бүхэн надад үлгэр мэт бас тэгээд яг л үнэн юм шиг санагдлаа. Даруйхан өөрийн гэртэй болж, эхнэр аван хүүхдүүддээ хотоос боов авчирч өгөхийг хүсэв. Тэр зуур айлын хүүхдүүд цугларан ирж тус тусын чулуун гэрийг эзэгнэн 拥有, 成主人 сууж хөл хөгжөөнтэй 有趣的, 快乐的 тоглоом эхэллээ. Хүүхдүүд бие биендээ айлчилж, бэлэг авч, наймаа хийж тоглоно.

Дасгал:

1. Тэднийх ямар голын хөвөөнд нутагладаг байсан бэ?
2. Хүүхдүүд гол дээр юугаар тоглож байна вэ?
3. Энэ хүүхдийн уйлсан учрыг хэлнэ үү?
4. Энэ хүүхэд ямар ямар тоглоомтой болов?
5. Цоохор хамартай жаалын гэрийн тухай ярина уу?
6. Энэ хүүхэд гол уруу явах гэж яагаад дурладаг болов?
7. 1-6-р бадгийг хятадаар орчуул.